



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024. 12. 18 № 03/10386

танай _____-ны № _____-т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ЭМЯ/20240102089 дугаартай “Улсын гуравдугаар төв эмнэлэгт эмнэлгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/” тендер шалгаруулалтын 1 дүгээр багцад оролцсон “Интер сайнс” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Интер сайнс” ХХК-аас ирүүлсэн гомдолд захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Мед буян” ХХК нь тендерээ нууцалж ирүүлсэн байхад шаардлагад нийцсэн гэж шалгаруулсан захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх тул хянан үзэхийг хүссэн байна.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 25.5-д “Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.” гэж, хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт “Оролцогч хуульд заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг энэ хуулийн 29.2-т зааснаар ил болгохгүйгээр илгээнэ.” гэж, Хүний хувийн мэдээлэл хамгаалал тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтад ““хүний эмзэг мэдээлэл” гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг” гэж тус тус заасан байна. “Мед буян” ХХК нь техникийн үзүүлэлт болон харьцуулсан хүснэгт, гэрээнд гарын үсэг зурах-үйлдвэрийн зөвшөөрөл-мэдэгдэл-гэрээ сертификат, гарын авлага, үзүүлэлт, каталог, эмнэлгийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ, хүний нөөцийн мэдээлэл, санхүүгийн тайлан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, лавлагааг тус тус ил болгохгүйгээр ирүүлсэн байхад дээрх хуульд нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/1254 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.


Тендер шалгаруулалтын 1 дүгээр багцын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "Интер сайнс" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ

A handwritten signature in black ink, appearing to read 'Ж. Ганбат', is written over a faint, dotted rectangular stamp. The signature is fluid and stylized.